



**“АБТС ББСБ” ХХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН 2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Тайлагнах хугацаа	2024.01.01-2024.12.31
Тайлан гаргасан	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Ням-Эрдэнэ

№	Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа
1	Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд ТУЗ болон удирдлагын багт засаглалын талаар мэдээлэл хүргүүлэх, хэрхэн оновчтойгоор компани дээр хэрэгжүүлэх арга боломжийн талаар тухай бүр зөвлөмж өгч ажиллав. Ингэснээр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороог байгуулах ажлыг хийж журам боловсруулах ажилд зөвлөгөө өгч батлуулав. Эрсдэлийн удирдлагын бодлого, Комплайнсын хяналтын заавар, Дотоод хяналтын бодлого, Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлого зэрэг бодлогын төслүүдийг боловсруулах ажилд зөвлөгөө өгч ТУЗ-д танилцуулж батлуулав. СЗХ-с батлагдан гарсан засаглалын кодексед нийцүүлэх ажил үргэлжилж байгаа ба компанийн засаглалтай холбоотой гарсан журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
2	ТУЗ-ийн гишүүдэд олгох сургалтын 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулав.
3	Компанийн шинээр орсон ажилчдад олгох сургалтын төлөвлөгөөг батлуулав.
Хувьцаа эзэмшигчдийн хурал	
3	ХЭ-ын 2024 оны хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлыг хуулийн дагуу зохион байгуулж ХЭХ-аар 5 асуудал хэлэлцүүлж хэлэлцсэн асуудалтай холбогдуулан тогтоол батлагдсан.
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал, Хороодын хурал	
4	“АБТС ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн хурлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж хэлэлцэх асуудлуудын хүрээнд холбогдох мэдээллийг бэлтгэн нийт 18 удаа хуралдаж хэлэлцсэн асуудлуудтай холбоотой тогтоол шийдвэр гарсан. Мөн ТУЗ-ийн дэргэд шинээр 3 хороо байгуулж үйл ажиллагааг ТУЗ-ийн хуралд танилцуулж компанийн засаглалыг сайжруулах бусад холбогдох журам, бодлогын баримт бичгийг боловсуурах, батлуулах үйл ажиллагаанд оролцож ТУЗ-ийн хурлаар

	<p>батлуулав. Үүнд: ТУЗ-ийн дэргэд нийт 3 хороо байгуулж тэдгээрийг дагаж гарсан хороодын үйл ажиллагааны журам болон бодлого шийдвэрүүд мөн компанийн засаглалын кодекстой холбоотой багц журмыг тус тус батлуулан ажилласан. Хороодын үйл ажиллагааг жигдрэх хүртэл 3 хорооны нарийн бичгийн даргын албан тушаалын хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд тус хороод нь тус бүр ээлжит 2 нийт 6 хуралдаж тогтоол зөвлөмжүүдийг батлуулан ажилласан.</p>
<p>Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, тайлан</p>	
5	<p>Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны 145 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-д заасны дагуу компанийн засаглалыг сайжруулах компанийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой сайн засаглалтай байлгах зорилгоор холбогдох хороо байгуулах түүнийг дагасан журам, бодлогын баримт бичгийг боловсруулах нийцүүлэх ажлыг шат дараатайгаар зохион байгуулж амжилттайгаар батлуулан мөрдөн эхэлсэн. Цаашдаа 2025 онд компанийн засаглалыг сайжруулах зорилгоор хийж хэрэгжүүлэх ажлын судалгааг хийн түүнтэй холбоотой бодлого, журам боловсруулах ажлыг судлаж байна.</p>
6	<p>Монгол улсын хууль тогтоомжид заасан тайлан тооцоог боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.</p>
<p>ТУЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилт</p>	
7	<p>ТУЗ болон хороодоос гарсан тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажилласан.</p>
<p>Компанийн бичиг баримтын бүрдэл, бүртгэл, хадгалалт</p>	
8	<p>ТУЗ-өөс баталсан тогтоол, хурлын баримтуудыг хөтлөн шаардлагатай асуудлаар дүн шинжилгээ дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулж компанийн ажилчдад зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан.</p>